



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Б.БАТТӨМӨР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

дод.од.од № ХТ/ЗТ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт <sup>18</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000235002862



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>

2023.01.30 № 01/285  
танай 2023.01.06 -ны № 22/81 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын гишүүн  
Б.Баттөмөрөөс Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын  
технологид тохирохгүй хүдрийн овоолгын талаар  
Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан  
асуулгатай танилцаад холбогдох мэдээллийг  
гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.  
Хавсралт.....хуудастай.



**Ж.ГАНБААТАР**

1508 03 0174

## АСУУЛГЫН ХАРИУ

**Асуулга 1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хоёр төрлийн овоолго байдаг. Эхнийх нь тодорхой нөхцөлд үр ашигтай буюу балансын бус хүдрийн дөрвөн овоолго, хоёр дахь нь исэлдсэн хүдрийн дөрвөн овоолго бий. Технологид тохирохгүй зэсийн хүдрийн овоолгыг хэдэн оноос эхэлж бий болгосон, одоогийн нөөц хэмжээ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын балансад бүртгэлтэй эсэх талаарх мэдээлэл:**

### **Хариулт 1:**

**1.1.Технологид тохирохгүй зэсийн хүдрийн овоолгыг хэдэн оноос эхэлж бий болгосон, одоогийн тоо хэмжээний талаар:**

Эрдэнэтийн-Овоо зэс-молибденийн ордод анх 1976 оноос хөрс хуулалт хийж, 1977 оноос исэлдсэн хүдрийг тусад нь овоолго үүсгэж эхэлсэн.

Баяжуулах үйлдвэрийг 1978 онд ашиглалтад оруулснаар хөрс, ядуу агуулгатай хүдэр (тухайн үед “забаланс” гэж нэрлэж байсан), мөн исэлдсэн хүдэр гэж ангилан тус тусад нь хурааж, овоолго үүсгэж ирсэн байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2018 оны А/132 дугаар тушаалаар баталсан “Ил уурхайгаас олборлож байгаа хүдрийн технологийн шаардлагыг тодорхойлох байгууллагын стандарт”-д “хөрс” гэдэг нь ашигт бүрдвэрийн агуулгагүй хоосон чулуулаг болон тодорхой нөхцөлд үр ашигтай (ядуу) хүдрийн нийлбэр тул үндсэндээ флотацын аргаар баяжуулах үйлдвэрт, мөн уусган баяжуулах технологиор ашиглахад өнөөгийн нөхцөлд үр ашиггүй байх магадлалтай, нарийвчлан судлах шаардлагатай хүдрийн төрөл гэж, “исэлдсэн хүдэр” гэдэг нь технологид исэлдсэн зэсийн эрдсийн харьцангуй агуулга 10%-иас дээш харьцаагаар илэрхийлэгдэх хүдэр гэж тус тус тодорхойлсон байдаг.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 0.202 хувийн дундаж агуулгатай, 451.0 мян.тонн металл агуулсан, 227.9 сая тонн ядуу агуулгатай хүдрийн 6 овоолго, 0.599 хувийн дундаж агуулгатай, 258.2 мян.тонн металл агуулсан, 51.9 сая тонн исэлдсэн хүдрийн 4 овоолго байна.

**1.2.Технологид тохирохгүй зэсийн хүдрийн овоолгууд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын балансад бүртгэлтэй эсэх талаар:**

Эрдэнэтийн-Овоо ордын овоолгуудад байгаа исэлдсэн болон ядуу агуулгатай хүдэр нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хүдрийн нөөц баялгийн балансад бүртгэлтэй байдаг бөгөөд тоо хэмжээний өөрчлөлт нь өдөр, сар, жил тутамд бүртгэгддэг.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) болон Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 409 дүгээр тушаалаар баталсан “Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу уурхайн ашиглалтын явцад үүссэн исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийн овоолгуудыг үүсгэхэд гарсан зардлыг 1 метр куб уулын цул болон 1 тонн хүдрийн өөрийн өртөгт оруулан тооцож, тухайн жилийн үйлдвэрлэлийн зардалд бүртгэдэг.

**Асуулга 2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын овоолгын хэмжээ, цэвэр нөөц, өнөөдрийн зах зээлийн үнэ, хэдэн овоолго ашиглаж байгаа болон ашиглагдахгүй байгаа, тэдгээрт хичнээн тонн цэвэр зэс агуулагдаж байгаа талаарх мэдээлэл:**

**Хариулт 2:** “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 0.202 хувийн дундаж агуулгатай, 451.0 мян.тонн металл агуулсан, 227.9 сая тонн ядуу агуулгатай хүдрийн 6 овоолго, 0.599 хувийн дундаж агуулгатай, 258.2 мян.тонн металл агуулсан, 51.9 сая тонн исэлдсэн хүдрийн 4 овоолго, нийт 10 овоолго байна. Эдгээр овоолгоос ядуу агуулгатай хүдрийн овоолго 4а, исэлдсэн хүдрийн 10а дугаар овоолгуудыг хаасан, дахин нэмээгүй байна. Бусад овоолгууд дээр уулын ажлын төлөвлөгөөний дагуу ядуу агуулгатай болон исэлдсэн хүдрийг буулгаж байна.

Эрдэнэт үйлдвэрийн хүдрийн нөөцийн балансад бүртгэлтэй ядуу агуулгатай болон исэлдсэн хүдрийн овоолгын мэдээлэл (2023.01.01-ний өдрийн байдлаар)

Хүснэгт 1

д/д	Овоолгын дугаар	Хүдрийн хэмжээ, мян.тн	Зэс		Овоолго үүсгэхэд гаргасан зардлын өнөөгийн үнэ цэнэ (мян.ам.долл.)	Ашиглалтын байдал
			агуулга, %	металл, тн		
<b>Нэг. Ядуу агуулгатай хүдрийн овоолго</b>						
1	Овоолго 2	6,255	0.382	23,888	10,488	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хүдэр буулгаж байгаа
2	Овоолго 8	58,405	0.209	122,093	1,731	
3	Овоолго 9	80,895	0.188	151,954	106,320	
4	Овоолго 9а	70,541	0.177	123,038	166,935	
5	Овоолго 9б	9,793	0.226	22,419	102,661	
6	Овоолго 4а	2,078	0.369	7,658	13,620	1997 оноос ашиглаагүй хаагдсан овоолго
<b>Дүн</b>		<b>227,965</b>	<b>0.202</b>	<b>451,049</b>	<b>401,755</b>	
<b>Хоёр. Исэлдсэн хүдрийн овоолго</b>						
1	Овоолго 2б	1,698	0.462	7,533	3,230	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хүдэр буулгаж байгаа
2	Овоолго 8а	15,244	0.491	74,073	253	
3	Овоолго 12	34,742	0.507	175,981	26,866	
4	Овоолго 10а	212	0.279	592	68,018	1987 оноос ашиглаагүй хаагдсан овоолго
<b>Дүн</b>		<b>51,896</b>	<b>0.599</b>	<b>142,000</b>	<b>98,366</b>	
<b>Нийт</b>		<b>279,861</b>		<b>593,049</b>	<b>500,122</b>	

Ядуу агуулгатай хүдэр нь флотацын аргаар баяжуулах үйлдвэрт, мөн нуруулдан уусгах технологиор ашиглахад өнөөгийн нөхцөлд үр ашиггүй тул нарийвчлан судлах шаардлагатай. Тиймээс Хүснэгт 1-д тусгасан 227.9 сая тонн ядуу агуулгатай хүдрийн овоолгоос 451.0 мян.тонн зэс авна гэж тооцох нь технологийн хувьд боломжгүй бөгөөд өнөөгийн нөхцөлд эдийн засгийн үр ашиггүй юм.

Харин нуруулдан уусгах технологиор ашиглах боломжтой 142 мян.тонн зэс агуулсан 51.9 сая тонн исэлдсэн хүдрийн нөөц байна.

Эрдэнэт үйлдвэр нь ядуу агуулгатай болон исэлдсэн хүдрийн овоолгуудыг үүсгэхэд гаргасан нийт зардлыг өнөөгийн үнэ цэнээр тооцвол 500.1 сая ам.доллар байна. Энэхүү зардлыг 1 метр куб уулын цул болон 1 тн хүдрийн өөрийн өртөгт оруулан тооцож, тухайн жилийн үйлдвэрлэлийн зардалд бүртгэсэн болно.

**Асуулга 3. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын төрийн эзэмших хувь хэмжээг бууруулсан тухай мэдээлэл. Үүнд “Эрдмин” ХХК-д Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн 51 хувь нь 25 хувь болсон, “Ачит Ихт” ХХК эзэмшиж байсан 34 хувь 0 болж бууруулсан нь хэзээ, хэний шийдвэрээр шийдсэн тухай мэдээлэл:**

### **Хариулт 3:**

**3.1. “Эрдмин” ХХК-д Эрдэнэт УБУ-ийн 51 хувь нь 25 хувь болсон нь хэзээ, хэний шийдвэрээр шийдсэн тухай мэдээлэл.**

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн “Эрдэнэт концерн байгуулах тухай” 255 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, гадаад худалдаа, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх улсын “Эрдэнэт” концерныг байгуулж, бүрэлдэхүүнд нь “Эрдэнэт үйлдвэр”-ийг оруулсан байна.

“Эрдмин” ХХК-ийг 1994 оны 3 дугаар сарын 18-нд үүсгэн байгуулсан бөгөөд “Эрдэнэт” концерн 51 хувийг, АНУ-ын RCM Inc (“АрСиЭм”) компани 49 хувийг эзэмшиж байсан.

“Эрдмин” ХХК-ийн үүсгэн байгуулагчдын 2000 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар “Эрдэнэт” концернын эзэмшиж байсан 51 хувийн 25 хувийг “Эрдэнэт үйлдвэр”-т эзэмшүүлэхээр тохиролцсон байна. Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт үйлдвэр”-ийн Зөвлөлийн 2001 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэлээр “1991 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн Монгол-Оросын Засгийн газар хоорондын хэлэлцээр, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Эрдмин” ХХК-ийн дүрмийн сангийн 25 хувийг “Эрдэнэт үйлдвэр” эзэмших” гэж үйлдвэрийн удирдлагад даалгасан байна.

Мөн “Эрдмин” ХХК-ийн Захирлуудын зөвлөлийн 2001 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар энэхүү асуудлыг хэлэлцэж, “Эрдэнэт үйлдвэр”-ийн эзэмших 25 хувийг баталгаажуулсан протокол үйлдсэн байна.

“Эрдмин” ХХК-ийн дүрмийн сан дахь хувь эзэмшлийн болон хувь эзэмшигчийн нэрийн өөрчлөлтийг тухай бүр Улсын бүртгэлийн гэрчилгээ болон Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээнд бүртгэсэн байна.

**3.2. “Ачит-Ихт” ХХК эзэмшиж байсан 34 хувь 0 болж бууруулсан нь хэзээ, хэний шийдвэрээр шийдсэн тухай мэдээлэл.**

Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 43 дугаар хуралдааны тэмдэглэлийн 6.5-д ““Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн балансын бус хүдрийн овоолгыг ашиглах талаар судлах” гэж заасныг үндэслэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд зэс боловсруулах үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэхээр 2010 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр 5/255-10 дугаартай гэрээг байгуулсан байна. Энэхүү гэрээнд гидрометаллургийн

үйлдвэрийн төсөлд хүдрийн овоолго нийлүүлж байгааг тооцон “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн эзэмшлийг 34 хувь байхаар, барилга байгууламжийн санхүүжилтийг бүрэн гаргаж байгааг тооцон “Ачит-Ихт” ХХК-ийн хувь эзэмшлийг 66 хувь байхаар тусгажээ.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан АИ-13/02 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-ний 2.2-т “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулахад шаардлагатай балансын бус хүдэр нийлүүлж байгааг үндэслэн “Ачит-Ихт” ХХК-ийн хувь хөрөнгийн 34 хувийг эзэмшинэ” гэж заасан байна. 2014 онд “Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэсийн үйлдвэр ашиглалтад орсон.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тушаалаар уг төслийн үр өгөөжийг судлах зорилго бүхий ажлын хэсэг байгуулсан. Энэхүү ажлын хэсгээс “Ачит-Ихт” ХХК-ийн барьсан гидрометаллургийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл нь үндэслэл муутай хийгдсэн, эдийн засгийн эрсдэл өндөр байх магадлалтай маш муу төсөл гэж, мөн “Ачит-Ихт” ХХК-ийн техник, эдийн засгийн үндэслэлд технологийн болон байгаль орчны эрсдэлийг үндэслэл муутай тооцоолон хийсэн байгаа тул энэ үйлдвэрийн үйл ажиллагаанд “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь хувь эзэмшиж оролцох шаардлагагүй. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь “Ачит-Ихт” ХХК-тай Иргэний хуулийн дагуу ажил үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллах нь зүйтэй гэж үзлээ.” гэсэн дүгнэлт гаргасан байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд Иргэний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.7 дахь хэсэг, 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг тус тус үндэслэн 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр 5/199-15 дугаартай гэрээг байгуулсан байна. Уг гэрээгээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн балансын бус хүдрийн овоолгыг “Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрт 20 жилийн хугацаанд ашиглаж, борлуулалтын орлогоос ашиглалтын төлбөрийг 2015 онд 0.5 хувиар, 2016 онд 1 хувиар, 2017 онд 1.5 хувиар, 2018 оноос эхлэн 2.0 хувиар улирал тутам тооцож, төлөхөөр тохиролцсон байна.

**Асуулга 4. Өнгөрсөн 30 жилд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ энэхүү овоолгыг яагаад ашиглаагүй талаарх мэдээлэл:**

**Хариулт 4:** Үйлдвэрлэлийн үндсэн технологийн процесст тохирохгүй ядуу агуулгатай болон исэлдсэн хүдрийн овоолгуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр өнгөрсөн жилүүдэд багагүй судалгаа хийж, гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хүрээлэн, технологи эзэмшигч болон хөрөнгө оруулагч компаниудтай хамтран ажиллаж ирсэн.

Эдгээр судалгааны үр дүнд дараах 2 төсөл хэрэгжсэн байна. Үүнд:

1. 1991 онд Засгийн газрын шийдвэрийн дагуу байгуулагдсан “Эрдэнэт” концерн нь 1994 онд АНУ-ын RCM Inc компанитай хамтран “Эрдмин” ХХК-ийг байгуулсан. “Эрдмин” ХХК нь исэлдсэн хүдрийг боловсруулж, катодын зэс үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлсэн бөгөөд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ тус компанийн 25 хувийг эзэмшдэг.

2. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2010 онд “Ачит-Ихт” ХХК-тай хамтран ядуу агуулгатай хүдрийг боловсруулж, катодын зэс үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан. Ингэхдээ “Ачит-Ихт” ХХК-ийн хувьцааны 34 хувийг авахаар

тохиролцсон байсан. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын 2014 оны 14 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн 2015 онд “Ачит-Ихт” ХХК-ийн хувьцааны 34 хувийг бус, харин бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос тодорхой хувиар ашиглалтын төлбөр авахаар харилцан тохиролцож, гэрээ байгуулсан байна. Өнөөдрийн байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь “Ачит Ихт” ХХК-ийн борлуулалтын орлогоос 2.0 хувийн ашиглалтын төлбөр авч байна.

Үүнээс гадна, “Зэс эрдэнийн хувь” ХХК нь Эрдэнэт үйлдвэрийн исэлдсэн хүдрийн овоолгуудыг түшиглэн жилд 10.0 мян.тонн катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг барьсан.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийг боловсруулах чиглэлээр туршилт судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг эрчимтэй хийж ирсэн. Тухайлбал: 2000-2005 онд БНСУ-ын Samsung болон Kores корпорациудтай хамтран цуврал туршилт, судалгааны ажлуудыг, 2004-2008 онд гидрometаллургийн аргаар зэсийн баяжмал болон хүдэр боловсруулах чиглэлээр Hydrocopper ба Galvanox технологиудыг судалж, лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтуудыг хийж байсан.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь эдгээр судалгааны ажлуудын үр дүнд үндэслэн өөрийн хүч бололцоог ашиглан, нэмэлт туршилт, судалгааны ажлуудыг хийсэн. Тухайлбал, 2014-2015 онд исэлдсэн хүдрийн баганан уусгалтын туршилтын ажил хийсэн бол, 2016 онд исэлдсэн хүдрийг SX/EW технологиор боловсруулж, жилд 6500 тн катодын зэс үйлдвэрлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.

2017 онд исэлдсэн хүдрийг SX/EW технологиор боловсруулж, жилд 6500 тн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр барих талбайд геотехникийн судалгаа ба байгаль орчны ерөнхий төлөв байдлын үнэлгээ хийлгэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 224 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 262 дугаар тогтоолоор баталсан “Эрдэнэт үйлдвэрийг 2031 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл”, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “... Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн уул уурхай-металлург-химийн үйлдвэрийн цогцолбор барьж, бүрэлдэхүүнд нь Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор боловсруулан, жилд 10.0 мян.тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулах төсөл тусгагдсан.

**Асуулга 5. Өнгөрсөн хугацаанд “Эрдмин” ХХК, “Ачит Ихт” ХХК-уудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулалт, төлсөн татварын хэмжээ жил тус бүрээр:**

**Хариулт 5:**

**5.1. “Эрдмин” ХХК-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулалт, төлсөн татварын хэмжээ жил тус бүрээр.**

“Эрдмин” ХХК нь 1997-2022 онд нийт 55 мян.тонн катодын зэс, 30.4 сая метр цахилгаан монтажны утас үйлдвэрлэж, 53.7 мян.тонн катодын зэс, 28.9 сая метр цахилгаан монтажны утас борлуулсан байна. Дээрх хугацаанд нийт 527.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 224.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, улс, орон нутгийн төсөвт нийт 139.2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Тус компанийн санхүүгийн тайланд үндэслэн боловсруулсан үйлдвэрлэл, эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн судалгааг хавсаргав. (Хавсралт 1)

**5.2. “Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулалт, төлсөн татварын талаар.**

“Ачит-Ихт” ХХК нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан 5/199-15 дугаар гэрээний дагуу овоолго ашиглалтын төлбөрийг борлуулалтын орлогоосоо 0.5-2.0 хувиар тооцож, ашиглалтын төлбөрийг улирал бүр төлдөг бөгөөд аудитын компаниар баталгаажуулсан борлуулалтын орлогын мэдээг манайд жил бүр ирүүлдэг.

“Ачит-Ихт” ХХК нь үйлдвэрлэл явуулж эхэлсэнээс хойш буюу 2014-2022 онд нийт 84.2 мян.тонн катодын зэс үйлдвэрлэсэн байна. Тус компанийн Эрдэнэт үйлдвэрт ирүүлдэг улирал бүрийн мэдээнээс нэгтгэхэд 2015-2022 онд нийт 1.3 их наяд төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.

**“Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрлэл,  
борлуулалтын орлогын мэдээ**

Хүснэгт 2

Он	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	Дүн
Борлуулалт /тэрбум төг/	-*	109.66	140.48	195.20	170.67	153.35	128.28	208.29	210.47	1,316.4
Зэс үйлдвэрлэл /тн/	1,402.3**	10,530.2	13,810.3	13,611.8	11,009.8	10,012.5	7,600.0	8,208.3	8,008.8	84,193.9

Тайлбар: \* “Ачит-Ихт” ХХК нь гэрээний дагуу 2015 оноос олборлолт, борлуулалтын мэдээг ирүүлж байна.

\*\* Үндэсний аудитын газраас 2018 онд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаас авав.

**Асуулга 6. Овоолгууд дээр катодын зэс ялгах хэдэн үйлдвэр ажиллаж байгаа болон ашиглаж байгаа хэлбэрийн талаарх мэдээлэл:**

**Хариулт 6:** Эрдэнэтийн-Овоо ордын исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийн овоолгуудыг түшиглэн 3 үйлдвэр ажиллаж байна. Үүнд:

1. “Эрдмин” ХХК нь исэлдсэн хүдрийг боловсруулж, жилд 2500 тн катодын зэс үйлдвэрлэх төслийг 1994 оноос хэрэгжүүлж, 1997 онд үйлдвэр нь ашиглалтад орсон. 1995-2011 онд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас 17.3 сая тонн исэлдсэн болон ядуу агуулгатай хүдэр худалдан авсан бөгөөд энэ нөөцөөр өнөөг хүртэл ажиллаж байна.

2. “Ачит-Ихт” ХХК нь 2010 оноос ядуу агуулгатай хүдрийг боловсруулж, жилд 10,000 тн катодын зэс үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлж, 2014 онд үйлдвэр нь ашиглалтад орсон. 2015 оны 6 дугаар сарын 26-нд байгуулсан гэрээний дагуу 2 дугаар овоолгыг ашиглан ажиллаж байна.



3. “Зэс эрдэнийн хувь” ХХК нь исэлдсэн хүдрийг боловсруулж, жилд 10,000 тн катодын зэс үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлж, үйлдвэрээ барьж байгуулан ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах гэрээ”-ний дагуу 8а дугаар овоолгоос 1.3 сая тонн хүдэр авч, үйлдвэрлэлийн туршилт хийж байна.

**Асуулга 7. Эдгээр үйлдвэрүүдэд овоолгыг эзэмшүүлж байгаа хууль эрхзүйн баримт бичгүүдийн нэгдсэн мэдээлэл /Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын зөвлөлийн шийдвэр, үйлдвэрийн захирлын хэлцэл гэх мэт/:**

**Хариулт 7:** Эрдэнэт үйлдвэр нь овоолго ашиглуулахтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахаар “Эрдмин” ХХК-тай 9 гэрээ, “Ачит-Ихт” ХХК-тай 7 гэрээ, “Зэс эрдэнийн хувь” ХХК-тай 6 гэрээг тус тус байгуулсан байна. (Хавсралт 2)

### **7.1. “Эрдмин” ХХК -ийн тухайд:**

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн “Эрдэнэт концерн байгуулах тухай” 255 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, гадаад худалдаа, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх улсын “Эрдэнэт” концерныг байгуулж, бүрэлдэхүүнд нь “Эрдэнэт үйлдвэр”-ийг оруулсан байдаг. “Эрдэнэт” концерн болон АНУ-ын RCM Inc компани Монгол-Америкийн хамтарсан “Эрдмин” ХХК-ийг 1994 оны 3 дугаар сарын 18-нд байгуулсан.

Монгол Улсын Худалдаа, үйлдвэрийн сайдын 1994 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн “Хамтарсан компани байгуулахыг зөвшөөрөх тухай” 296 дугаар тушаалаар “Монгол Улсын “Эрдэнэт” концерн болон АНУ-ын Колорадо мужийн “АрСиЭм”(RCM) компанийн хооронд 1994 оны 3 дугаар сарын 18-нд байгуулсан гэрээний дагуу уурхайн хаягдал овоолго, балансын бус хүдрээс уусгах аргаар зэс ялгаж үйлдвэрлэх Монгол-Америкийн хамтарсан “Эрдмин” ББХК-ийг 100,000.00 ам.долларын дүрмийн сантай, 40 жилийн хугацаагаар Эрдэнэт хотод байгуулах”-ыг зөвшөөрсөн байна.

1994-2006 оны хооронд “Эрдмин” ХХК-ийн Дүрмийн сангийн өөрчлөлт, Үүсгэн байгуулагчид, Хувьцаа эзэмшигчдын хооронд Дүрмийн сан дахь хувь эзэмшлийн талаар болон хувь эзэмшигчийн нэрийн талаар оруулсан өөрчлөлтүүдийг тухай бүр тухайн үеийн төрийн захиргааны, тухайлбал, Татварын ерөнхий газар, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг зэрэг байгууллагууд Улсын бүртгэлийн гэрчилгээ болон Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээнд бүртгэсэн байна.

Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэр, “Эрдэнэт концерн” ХХК, “Эрдмин” ХХК-ийн хооронд 1997 оны 7 дугаар сарын 15-ны өдөр “Лицензээр олгогдсон уурхайн эдэлбэр газрын хэсгийг болон овоолгуудыг ашиглуулах” гэрээг байгуулсан ба уг гэрээний 1.1-т “Эрдэнэтийн уурхайн балансын бус хүдрийн 2,6,4,5,5а,3а овоолгууд, хаягдлын 1, 3-р овоолгууд, мөн ирээдүйд бий болох бусад балансын бус хүдрийн овоолгууд багтана” гэж заасан байна. Мөн Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт үйлдвэр”-ийн Зөвлөлийн 2002 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 32 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.21 дэх заалт, 2006 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 36 дугаар хуралдааны тэмдэглэлийн 4.3 дахь заалт, 2007 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 37 дугаар хуралдааны тэмдэглэлийн 3.4 дэх заалт зэргийг тус тус үндэслэн

“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Эрдмин” ХХК-ийн хооронд 2001-2010 онд байгуулсан аж ахуйн гэрээ, түүний нэмэлтүүдийг байгуулсан байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Эрдмин” ХХК-ийн хооронд 2006 оны 12 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан хүдэр нийлүүлэх гэрээгээр 2а овоолгоос 5.3 сая тонн хүдрийг “Эрдмин” ХХК-д худалдахаар тохиролцсон байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь дээрх баримт бичгүүдийг үндэслэн 1995-2011 онд “Эрдмин” ХХК-д 17.3 сая тонн исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийг худалдсан байна.

### **7.2. “Ачит-Ихт” ХХК-ийн тухайд:**

“Эрдэнэт үйлдвэр” ХХК ба “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд 2010 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр “Эрдэнэт” үйлдвэрийн овоолгыг түшиглэн зэсийн үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай” 5/225-10 дугаар гэрээг байгуулахдаа “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 43 дугаар хуралдааны тэмдэглэлийн 6.5 дахь заалтыг үндэслэсэн байна.

Мөн “Эрдэнэт үйлдвэр” ХХК ба “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдөр “Хамтран ажиллах тухай” АИ-13/02 дугаар гэрээг байгуулахдаа Монгол-Оросын Засгийн газар хоорондын хэлэлцээр, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн дүрэм, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлийн Монголын хэсгийн 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрийн 9 дүгээр заалтыг тус тус үндэслэсэн байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн балансын бус хүдрийн №2 овоолгыг “Ачит-Ихт” ХХК-д ашиглуулах, ингэхдээ төлбөрийг борлуулалтын орлогоос 0.5-2.0 хувь хүртэл улирал бүр төлөх тухай агуулгатай 5/199-15 дугаар гэрээг 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулахдаа Монгол улсын Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.7 дахь хэсэг, 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг тус тус үндэслэсэн байна.

### **7.3. “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн тухайд:**

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийг 34,173.0 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар, гадаад худалдааны үйл ажиллагаа явуулах чиглэлээр 16036 иргэн үүсгэн байгуулж, 2010 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Монгол Улс болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Төрийн өмчийн хорооны 2012 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн болон 2012 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Төрийн өмчийн хорооны Тамгын газрын даргын 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 16/919 тоот албан бичиг, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн 2013 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн ЗГ-1/45 тоот албан бичиг зэргийг үндэслэн “Зэс эрдэнийн хувь” ХХК-тай хамтран ажиллах гэрээнүүдийг байгуулсан байна.

Эрдэнэт үйлдвэрийн 8а, 12 дугаар овоолгыг “Зэс эрдэнийн хувь” ХХК-д ашиглуулахаар “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах” 5/277-15 тоот гэрээг “Зэс эрдэнийн хувь” ХХК, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хооронд 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан.

Энэхүү гэрээг байгуулахдаа Монгол Улсын Иргэний хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах багц хуулиуд, Орхон аймгийн нутгийн захиргаа, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хооронд 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Хамтын ажиллагааны тухай хэлэлцээр, “Зэс эрдэнийн хувь” ХХК, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хооронд байгуулагдсан 2013 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 5/096-13 тоот “Хамтран ажиллах гэрээ”-г тус тус үндэслэсэн байна.

**Асуулга 8. Овоолго ашиглуулсны төлбөрт “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ төлбөр авдаг болон худалддаг эсэх талаар. Хэрвээ төлбөр авдаггүй үнэгүй ашиглуулдаг бол яагаад?**

**Хариулт 8:** “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийн овоолгыг түшиглэн “Эрдмин” ХХК, “Ачит ихт” ХХК нь катодын зэсийн үйлдвэрлэл явуулж байна. Мөн “Зэс эрдэнийн хувь” ХХК нь 2022 оны сүүлээс үйлдвэрлэлийн туршилтыг эхлүүлсэн.

### **8.1. “Эрдмин” ХХК-ийн тухайд:**

#### Худалдсан хүдрийн талаар:

“Эрдмин” ХХК нь исэлдсэн хүдрийг боловсруулж, жилд 2,500 тн катодын зэс үйлдвэрлэх төслийг 1994 оноос хэрэгжүүлж, 1997 онд үйлдвэр нь ашиглалтад орсон. 1996-2011 онд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас 17.3 сая тонн исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийг 6.9 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна. Үүнд:

- 1996-2011 онд 9.2 сая тонн исэлдсэн хүдрийг тухайн жилд байгуулсан гэрээний дагуу худалдан авч, төлбөрт 4.3 тэрбум төгрөг төлсөн.
- 2006 оны 12 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан гэрээний дагуу 5.3 сая тонн исэлдсэн хүдрийн нөөцтэй 2а дугаар овоолгыг 1.3 сая ам.доллараар 6 жилд хуваан төлөх нөхцөлтэйгээр худалдан авсан бөгөөд тухайн үеийн ханшаар 1.5 тэрбум төгрөг төлсөн.
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын 2006 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 219 дүгээр тушаалын дагуу 2 дугаар овоолгоос 2.8 сая тонн ядуу агуулгатай хүдэр худалдан авч, төлбөрт 1.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий байгууламжийг Эрдэнэт үйлдвэрт шилжүүлснээр төлбөрийг барагдуулсан.

“Эрдмин” ХХК-д 1996-2011 онд худалдсан исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийн мэдээллийг Хавсралт 3-т үзүүлэв.

#### Ногдол ашгийн талаар:

“Эрдмин” ХХК нь 1997-2004 онд ногдол ашиг зарлаж, олгоогүй. Харин 2005 оноос жил бүр ногдол ашиг хуваарилж байна. 2005-2022 онд нийт 124.8 сая ам.долларын ногдол ашиг зарласнаас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т 31.2 сая ам.долларын ногдол ашиг хуваарилж, олгосон. “Эрдмин” ХХК-ийн хуваарилсан ногдол ашгийн мэдээллийг Хавсралт 4-д үзүүлэв.

### **8.2. “Ачит-Ихт” ХХК-ийн тухайд:**

“Ачит-Ихт” ХХК нь 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан 5/199-15 тоот гэрээний дагуу балансын бус хүдрийн 2 дугаар овоолгыг ашиглаж, овоолго ашигласны төлбөрийг катодын зэс борлуулсан орлогоос 2015 онд 0.5 хувиар, 2016 онд 1.0 хувиар, 2017 онд 1.5 хувиар, 2018 оноос 2.0 хувиар тооцон улирал бүр төлж байна.

“Ачит-Ихт” ХХК нь 2015-2022 онд овоолго ашигласны төлбөрт нийт 24.1 тэрбум төгрөг төлөхөөс 20.6 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 3.5 тэрбум төгрөгийн авлагатай байна. Энэхүү авлагад Үндэсний аудитын газрын 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн “Төлбөр барагдуулах тухай” 01/84 ГАГ-2017/01-ДА дугаар актын дагуу “Ачит-Ихт” ХХК-ийн төлөх 1.7 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар багтсан болно. “Ачит-Ихт” ХХК-ийн овоолго ашиглалтын төлбөрийн мэдээллийг Хавсралт 5-д үзүүлэв.

### **8.3. “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн тухайд:**

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь тус компанитай 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах тухай” 5/277-15 дугаар гэрээний дагуу 2022 онд үйлдвэрлэлийн туршилт явуулахад нь зориулж, 1.3 сая тонн исэлдсэн хүдэр нийлүүлсэн. “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн хооронд 2015 онд байгуулсан 5/277-15 дугаар гэрээний 2.6-д “үйлдвэрийг улсын комисс хүлээн авснаас хойш 1 сарын дотор овоолгын төлбөр, хамтын ажиллагааны талаар нэмэлт гэрээ хийх” тухай заасан байна. Одоогийн байдлаар “Зэс эрдэнийн хувь” ХХК нь исэлдсэн хүдрийн овоолгуудыг түшиглэн жилд 10.0 мян.тонн катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг Улсын комисст хүлээлгэн өгөөгүй.

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын исэлдсэн хүдрийн 8а, 12-р овоолгуудыг түшиглэн HL-SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголтой холбоотой асуудлыг урьдчилсан байдлаар хэлэлцэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр болсон өргөтгөсөн хуралдаанаар гишүүдийн 100%-ийн саналаар хойшлуулах шийдвэр гаргасан ба тус техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголд дараах асуудлыг тодорхой болгосны дараагаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан болно. Үүнд:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын исэлдсэн хүдрийн 8а, 12-р овоолгуудын нөөц нь тодорхой бус бөгөөд Монгол улсын Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам”-ын 3.4-т “Үүсмэл орд дахь ашигт малтмалын нөөц, агуулгын хэмжээг эрх бүхий байгууллагаар тодорхойлуулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байна”, мөн “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 4.3-т “Үүсмэл ордын нөөц, орд ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шаардлагатай тохиолдолд тодотгол хийж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох дүгнэлт, шийдвэр гаргуулна” гэж тус тус заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь тус овоолгуудын нөөцийг эрх бүхий байгууллагаар тодорхойлуулж, Эрдэс баялгийн

мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн Улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай гэж үзсэн.

**Асуулга 9. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:**

**Хариулт 9:** “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь үйлдвэрийн урт хугацааны хөгжлийн бодлогыг цогцоор нь авч үзэж, 2017 онд “Эрдэнэт үйлдвэрийг 2031 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг боловсруулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Засгийн газарт танилцуулсан.

Энэхүү цогц бодлогын хүрээнд юуны өмнө үйлдвэрлэлийн технологид тохирохгүй исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийг эдийн засгийн эргэлтэнд оруулах чиглэлээр, тухайлбал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн уул уурхай-металлург-химийн үйлдвэрийн цогцолбор барьж, бүрэлдэхүүнд нь Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX/EW) технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэр барих томоохон зорилт дэвшүүлсэн.

Энэхүү зорилт төр, засгийн бодлого, шийдвэрт тусгагдан батлагдсан бөгөөд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын зүгээс өөрийн үүсмэл ордод түшиглэн исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор боловсруулж, жилд 10.0 мянган тн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулах ажлыг эхлүүлээд байна. Үүнд:

1. Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг үндэслэн Эрдэнэтийн-Овоо ордын овоолгод байгаа исэлдсэн хүдрийн шинж чанар, нөөцийг анх удаа нарийвчлан судалж, эдийн засгийн ач холбогдлыг тодорхойлон үүсмэл ордын нөөцийн тайланг боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын ашигт малтмалын нэгдсэн тоо бүртгэлд “Үүсмэл орд”-ын нөөцөөр бүртгүүлсэн.

2. Катодын зэсийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

3. Катодын зэсийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн СТР/22-03-01 дүгээр дүгнэлтийг гаргуулсан бөгөөд зарим шаардлагатай асуудлыг дахин нягталж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

4. 2023 оны төлөвлөгөөнд Катодын зэсийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төслийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэсний дараа исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор боловсруулж, жилд 10.0 мянган тн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## “Эрдмин” ХХК-ийн санхүү, эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд

Он	Үйлдвэрлэл		Борлуулалт		Санхүүгийн тайлангийн үзүүлэлт /сая.төг/		Улс, орон нутгийн төсөвт төлсөн татвар /сая төг./
	катодын зэс /тн/	цах. кабель /мян.м/	катодын зэс /тн/	цах. кабель /мян.м/	бор. орлого	цэвэр ашиг	
1997	2,757.6	-	2,709.3	-	4,064.0	-	68.8
1998	2,319.6	-	2,312.1	-	3,352.6	-	69.2
1999	1,534.9	-	1,553.2	-	2,362.2	-	172.1
2000	641.3	-	684.8	-	1,332.0	-	77.2
2001	1,476.0	-	1,388.4	-	2,252.2	-	118.6
2002	1,469.0	-	1,490.8	-	2,502.6	-	137.4
2003	1,341.0	-	1,328.6	-	2,604.0	-	149.8
2004	2,376.0	-	2,451.2	-	8,270.2	2,549.3	694.1
2005	2,476.0	-	2,464.1	-	9,927.3	3,966.7	1,302.7
2006	2,617.0	-	2,372.8	-	20,304.6	11,680.0	5,103.6
2007	3,006.0	-	3,166.8	-	25,199.9	13,321.1	7,571.9
2008	2,595.0	421.6	2,604.1	16.1	18,413.3	8,823.0	5,773.9
2009	2,470.0	565.3	2,323.3	256.3	16,826.9	8,020.8	2,739.4
2010	2,735.0	795.7	2,801.9	1,018.5	27,339.0	14,501.4	7,255.0
2011	2,397.0	2,519.6	2,361.6	2,078.9	28,232.5	14,510.6	7,914.3
2012	2,282.2	3,444.7	2,120.9	2,906.5	23,904.6	10,857.8	5,793.6
2013	2,344.2	3,254.7	2,201.6	3,368.1	26,046.3	11,910.7	7,661.9
2014	2,132.0	5,161.5	1,920.4	3,874.2	25,836.9	11,986.4	6,016.9
2015	2,159.8	1,525.7	1,841.3	1,950.0	19,473.5	7,715.8	4,574.1
2016	2,009.1	919.4	2,100.8	1,149.3	22,558.3	9,309.5	4,783.4
2017	2,024.8	1,357.7	2,020.3	2,169.6	32,232.8	14,005.2	8,310.4
2018	2,097.5	2,588.9	1,950.7	2,052.3	32,947.3	15,037.9	7,772.5
2019	2,015.9	2,083.0	1,960.2	2,116.2	33,121.2	11,428.0	8,604.9
2020	1,904.3	1,991.9	1,839.6	2,248.3	33,318.8	12,079.7	9,983.5
2021	1,865.5	1,514.6	1,841.2	1,475.7	51,033.6	24,724.7	21,559.7
2022	1,965.0	2,216.2	1,919.9	2,297.8	54,323.2	*18,134.7	14,988.8
<b>Нийт</b>	<b>55,012.4</b>	<b>30,361.1</b>	<b>53,731.0</b>	<b>28,978.3</b>	<b>527,781.1</b>	<b>224,564.2</b>	<b>139,198.8</b>

\*Тайлбар: 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан эцэслэн батлагдаагүй тул 2022 оны "Цэвэр ашиг"-ийг 2022.09.30-ны өдрийн байдлаар харуулав.

“Эрдмин” ХХК, “Ачит-Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК-иудтай  
байгуулсан гэрээнүүд

Д/д	“Эрдмин” ХХК	“Ачит-Ихт” ХХК	“Зэс эрдэнийн хувь” ХХК
1.	Монгол-Оросын хамтарсан Эрдэнэт үйлдвэр, “Эрдэнэт концерн”, “Эрдмин” ХХК-ийн хооронд 1997 оны 07 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан “Лицензээр олгогдсон уурхайн эдэлбэр газрын хэсгийг болон овоолгуудыг ашиглуулах гэрээ”	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд 2010 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр байгуулагдсан 5/225-10 дугаартай гэрээ	“Зэс эрдэнийн хувь” ХК, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хооронд 2013 оны 05 дугаар сарын 06-ны өдөр байгуулагдсан 5/096-13 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”
2.	Эрдэнэт үйлдвэр, “Эрдмин” ХХК-ийн хооронд 2001 оны 02 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан гэрээ	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд 2011 оны 07 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан 01 дугаартай “Газар ашиглах тухай гэрээ”	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХК-ийн хооронд 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгуулагдсан 5/346-14 дугаартай “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх” гэрээ
3.	Эрдэнэт үйлдвэр, “Эрдмин” ХХК-ийн хооронд байгуулсан 2002 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 2-58 дугаартай гэрээ	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан АИ-13/02 дугаартай “Хамтран ажиллах” гэрээ	“Зэс эрдэнийн хувь” ХК, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хооронд 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан 5/277-15 дугаартай “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах” гэрээ
4.	Эрдэнэт үйлдвэр, “Эрдмин” ХХК-ийн хооронд 2003 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан гэрээ	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдөр байгуулагдсан 5/199-14 дугаартай “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглуулах” тухай гэрээ	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХК, “Ферростаал Монголиа” ХХК-иудын хооронд 2016 оны 10 дугаар сарын 04-ны өдөр байгуулагдсан 5/279-16 дугаартай “Исэлдсэн хүдрийн 8а, 12 дугаар овоолгуудаас технологийн туршилтын дээж авах” гэрээ
5.	Эрдэнэт үйлдвэр, “Эрдмин” ХХК-ийн хооронд байгуулсан 2004 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 4/056-4 дугаартай гэрээ	“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байгуулагдсан “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх” тухай гэрээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн хооронд 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдөр байгуулагдсан 5/300-20 дугаартай “Эвлэрлийн гэрээ”

6.	Эрдэнэт үйлдвэр, "Эрдмин" ХХК-ийн хооронд байгуулсан 2005 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 6/176-5 дугаартай гэрээ	"Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Ачит-Ихт" ХХК-ийн хооронд 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулагдсан 5/199-15 дугаартай гэрээ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Зэс эрдэнийн хувь" ХХК-ийн хооронд 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулагдсан 5/270-21 дугаартай "Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглуулах" гэрээ
7.	Эрдэнэт үйлдвэр, "Эрдмин" ХХК-ийн хооронд 2006 оны 12 дугаар 29-ний өдрийн "Хүдэр нийлүүлэх гэрээ",	"Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Ачит-Ихт" ХХК-ийн хооронд 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан 5/199-15 дугаартай гэрээнд оруулсан нэмэлт	
8.	Эрдэнэт үйлдвэр, "Эрдмин" ХХК-ийн хооронд 2007 оны 01 дүгээр сарын 11-ний 6/176-5 дугаартай гэрээний нэмэлт		
9.	"Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Эрдмин" ХХК-ийн хооронд 2010 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 6/176-5 дугаартай гэрээний нэмэлт		
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>7</b>	<b>6</b>
<b>Бусад баримт бичиг</b>			
<b>Д/д</b>	<b>"Эрдмин" ХХК</b>	<b>"Ачит-Ихт" ХХК</b>	
1.	Эрдэнэт үйлдвэрийн 2 дугаар овоолгыг "Эрдмин" ХХК-д шилжүүлсэн 2006 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн акт	Ашигт малтмал, газрын тосны газраас "Ачит-Ихт" ХХК-д 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдөр "Ашигт малтмалын үүсмэл ордын ашиглалт"-ын UN-000001 тоот тусгай зөвшөөрлийг 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийг дуустал хугацаагаар олгосон.	



## “Эрдмин” ХХК-д худалдсан хүдэр, түүний төлбөрийн тооцоо

Он	Нийлүүлсэн хүдэр /мян.тн/	Үнэ ам.долл/тн	Төлбөл зохих /сая төгрөг/			Төлсөн /сая төгрөг/
			Нийт	Үүнээс:		
				Хүдэр	Тээвэр	
1996	2,703.7	0.10	161.5	161.5	-	161.5
2001	996.18	0.10	142.2	142.2	-	142.2
2002	355.3	0.10	40.6	40.6	-	40.6
2003	1,609.3	0.15	235.1	235.1	-	235.1
2004	984.3	0.15	173.2	173.2	-	173.2
2006	602.0	0.25	428.7	389.8	38.8	428.7
2007	247.35	0.50	196.9	170.5	26.4	196.9
2008	989.4	0.50	1,575.7	1,083.7	492.0	1,575.7
2009	438.6	0.50	738.7	531.4	207.3	738.7
2010	173.4	0.75	365.4	258.8	106.6	365.4
2011	122.4	0.75	226.5	172.6	53.9	226.5
<b>Нийт</b>	<b>9,221.93</b>		<b>4,284.7</b>	<b>3,359.6</b>	<b>925.1</b>	<b>4,284.7</b>

## “Эрдмин” ХХК-д худалдсан овоолго, түүний төлбөрийн тооцоо

Он	Овоолгын дугаар	Хүдрийн хэмжээ /мян.тн/	Үнэ ам.долл/тн	Төлбөл зохих /сая төгрөг/	Төлсөн /сая төгрөг/
2006	№2а овоолго	5,267.3	0.25	1,525.1	1,525.1
2006	№2 овоолго	2,800.0	0.346	1,138.6	1,138.6
<b>Дүн</b>		<b>8,067.3</b>		<b>2,663.7</b>	<b>2,663.7</b>

## Тайлбар:

\*Төлбөр тооцоог тухайн үеийн ам.долларыг төгрөгтэй харьцах ханшаар хөрвүүлэн хийж байсан болно.

\*\*“Эрдмин” ХХК-д 1996-2011 онд гэрээний дагуу нийт 17.3 сая тонн хүдрийг нийт 6,948.4 сая төгрөгөөр худалдсан. Үүнд:

1. Уурхайгаас нийт 9,221.93 мянган тонн исэлдсэн хүдрийг тээвэрлэн борлуулж, хүдрийн төлбөрт 3,359.6 сая төгрөг, хүдэр тээвэрлэлтийн төлбөрт 925.1 сая төгрөг, нийт 4,284.7 сая төгрөгөөр худалдсан.
2. 2006 онд балансын бус хүдрийн №2а овоолго болон исэлдсэн хүдрийн №2 овоолгоос 2,800 мянган тонныг нийт 2,663.7 сая төгрөгөөр худалдсан.

## “Эрдмин” ХХК-ийн зарласан болон хуваарилсан ногдол ашиг

/мянган ам.доллар/

Он	Зарласан ногдол ашиг	Үүнээс: - "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-д хуваарилсан 25%.
1997-2004	-	-
2005	500.00	125.00
2006	12,500.00	3,125.00
2007	10,000.00	2,500.00
2008	5,000.00	1,250.00
2009	7,000.00	1,750.00
2010	8,500.00	2,125.00
2011	12,000.00	3,000.00
2012	10,000.00	2,500.00
2013	7,000.00	1,750.00
2014	8,000.00	2,000.00
2015	4,000.00	1,000.00
2016	3,200.00	800.00
2017	5,000.00	1,250.00
2018	6,000.00	1,500.00
2019	6,875.00	1,718.75
2020	4,295.00	1,073.75
2021	7,000.00	1,750.00
2022	8,000.00	2,000.00
<b>Нийт</b>	<b>124,870.00</b>	<b>31,217.50</b>

\*Тайлбар: “Эрдмин” ХХК нь 2004 оноос анхны хөрөнгө оруулалтаа нөхөж, ашигтай ажиллаж эхэлсэн. Ашиггүй ажилласан 1997-2004 онд ногдол ашиг зарлаагүй болно.

## “Ачит ихт” ХХК-ны 2015-2022 онд овоолго ашигласан төлбөрийн тооцоо

/сая төгрөг/

Он	Борлуулалтын орлого	Бодох хувь	Борлуулалтын орлогоос тооцсон хувь	НӨАТ	Төлбөл зохих нийт төлбөр	Төлсөн дүн	Үлдэгдэл	
							Дугуу төлөлт	НӨАТ
2015	109,659.89	0.5	548.30	-	548.30	548.30	-	-
2016	140,481.00	1.0	1,404.81	-	1,404.81	1,404.81	-	-
2017	195,197.45	1.5	2,927.96	-	2,927.96	2,927.96	-	-
2018	170,671.95	2.0	3,413.44	341.34	3,754.78	3,413.44	-	341.34
2019	153,353.86	2.0	3,067.08	306.71	3,373.78	3,067.08	-	306.71
2020	128,283.10	2.0	2,673.93	267.39	2,941.33	2,673.93	-	267.39
2021	208,292.81	2.0	4,165.86	416.59	4,582.44	4,165.86	-	416.59
2022	210,473.47	2.0	4,209.47	420.95	4,630.42	2,453.10	1,756.37	420.95
<b>Дүн</b>	<b>1,316,413.52</b>		<b>22,410.85</b>	<b>1,752.98</b>	<b>24,163.82</b>	<b>20,654.48</b>	<b>1,756.37</b>	<b>1,752.98</b>
*Кэй Пи Эм Жи Аудитаар 2015 оны зөрүү					2.7	2.7	-	
<b>Нийт</b>			<b>22,410.85</b>	<b>1,752.98</b>	<b>24,166.54</b>	<b>20,657.19</b>	<b>3,509.35</b>	

\*Тайлбар: “Ачит ихт” ХХК нь борлуулалтын орлогоос хувь тооцуулан овоолго ашигласны төлбөр төлөхдөө борлуулалтын орлогын мэдээг дараа улирлын эхний сард ирүүлдэг. 2016 онд тус компанийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн Кэй Пи Эм Жи ХХК-ийн аудитын дүгнэлтээр борлуулалтын орлого залруулагдсан. Энэхүү орлогын зөрүүнээс “Ачит ихт” ХХК нь 2.7 сая төгрөгийг үйлдвэрийн газарт нэмж төлсөн.